

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Сайншанд сумын 8 дугаар баг нийтийн орон сууц 245 дугаар байрны гадна фасад, дэврийн засварын ажил

А. Ажил гүйцэтгэх хугацааны график /хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

Б. Соёлын төвийн барилгын засварын ажлыг Барилгын норм ба дүрэм /БНБД/, стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх.

В. Үнийн саналд зураг төсвийн үнийг 1 768 800 /Нэг сая долоон зуун жаран найман мянга найман зуун/ төгрөгөөр тооцох, захиалагчийн хяналтын зардлыг Барилга угсралтын ажлын төсөвт өртгийн дүнгийн 2%-иар, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн хяналтын зардлын 50%-иар тооцож тусгаж ирүүлнэ.

Г. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах.

Д. Төсөв зохиохдоо Барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөт ашиг, техник хяналт, нормчлолын сан, НӨАТ, магадлангүй ажлын зардал зэр гийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНБД "Ү" 81-95-12-г мөрдлөг болгоно.

Е. Авто тээврийн зардлыг ЗТЯ-ны 2013.07.10-ны өдрийн 162 тоот тушаалаар батлагдсан жилийн тарифаар тооцно.

Ё. ЗТБХБС-ын 2012 оны 18 дугаар тушаалаар машин механизмын зардлыг тооцож ирүүлнэ.

Ж. Үнийн тарифийг тооцон ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.

З. Барилгын их засварын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ.

1. Гадна фасадны өнгөлгөө, засварын ажил

Гадна ханын хуучин будагтай гадаргууг торны хамт бүрэн буулгана. Одоо байгаа гадна ханын хөөсөнцөр дулаалгын бэхлэгээг сайжруулна. Хөөсөнцөр хавтангийн зай завсрыг баллонтой хөөсөөр дүүргэж сайтар битүүмжилнэ.

Дулаалгын хавтанцар дээр 3 үе сайн чанарын шавардлага хийнэ. Энэ нь хавтанцар дээр 1 үе торыг нааж торны гаднаас 2 үе шавардлага хийсний дараа хөрсжүүлэлт хийж барзгар гадаргуу үүсгэнэ.

Гадна ханыг стандартын шаардлага хангасан сайн чанарын эмульсэн будгаар будна. Гадна фасадны заслалын ажилд хэрэглэх будгийг MNS5252:2003 стандартын техникийн шаардлагын дагуу /Солонгос улсын SAMHWA брэндийн гадна эмульсэн будагтай дүйцэхүйц/ чанартай сайн материалыг сонгон хэрэглэх шаардлагатай. Гадна ханын эмульсны өнгийг ашиглагч байгууллагатай зөвшилцөн сонгоно.

Хөөсөн фасадны өнцөг булан гэмтэхээс сэргийлж цоолтуур бүхий нимгэн булан суурилуулна. Хананд хэрэглэх торыг 10 см зөрүүлэн наана.

Цонхны амалгаа, тагтны хавтангийн доод хэсэг, ирмэгүүдийг сайн чанарын эмульсэн будгаар будна мөн цоколын хананд жижиг ширхэгтэй чулуун өнгөлгөөг хийнэ.

Цонхонд усны хаялага төмрийг чанартай сайн материал ашиглан гүйцэтгэнэ.

Барилгын бетон хаяавчийг БМ-100 маркын бетоноор цутгах бөгөөд зураг төслийн дагуу чанартай сайн гүйцэтгэнэ. *(Бетон хаяавчийг доорх хөрсийг сайтар нягтарцуулж бэлтгэсний дараа хаяавчны бетоныг цутгах шаардлагатай!)*

2. Дээврийн ажил

Дээврийн ажлыг гүйцэтгэхдээ БНБД 31-02-03, БНБД 31-07-05, БНБД 31-08-05 бусад норм, стандартыг мөрдлөг болгоно. Дээврийн ажлыг дулааны улиралд чанарын маш өндөр түвшинд хийж гүйцэтгэх шаардлагатай. Дээврийн ажлыг зураг төсөвт тусгасны дагуу гүйцэтгэнэ.

Хуучин муудсан хуйлмал материалан дээврийг бүрэн хуулна. Дээврийн хог шороог цэвэрлэж шүүрсэний дараа ажлаа эхлүүлнэ. Дээвэрт 15 мм зузаантай бетон тэгшилгээ хийнэ. Үүний дээр битум массаар суурь хөрөжүүлэлт хийж, ОХУ-д үйлдвэрлэсэн бикрость маркын ус тусгаарлагч чулуугүй хар цаасыг дэвсгэр нэг үе, мөн маркын ус тусгаарлагч чулуутай хар цаасыг нэг үе СНиП 23-01-99*, БНБД81-52-05-ыг баримтлан хийж гүйцэтгэнэ.

Парапедний хананд цемент шохойн зуурмагаар гар аргаар сайн чанартай шавардлага хийж прапедний дээд талд 1:2 шингэн шилтэй цементэн зуурмагаар хийнэ.

Барилгын борооны усыг зайлуулах PVC хоолой /100мм/-г шинээр угсарна.

Тендерг шалгарсан гүйцэтгэгч нь:

1. Барилгын засварын ажлыг батлагдсан зураг төсөл, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Барилгын ажлыг эхлүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах, хашаа барих зэрэг шаардлагатай арга хэмжээг авч гэнэтийн аюул осол гаргахгүй байхаар ажиллана.
4. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.
5. Барилгын талбайд ажлын журнал, батлагдсан зураг төсөл, хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.
6. Барилгын засварын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.

7. Барилгын зураг төсөлд зааснаас зайлшгүй тохиолдолд өөрчлөлт оруулах болвол захиалагч болон зураг төслийн байгууллагатай зөвшилцөнө. Зөвшөөрөлгүйгээр газар дээр өөрчлөхийг хориглоно.
8. Барилгын тухай хуулийн 14.3-т заасны дагуу ашиглалтанд хүлээлгэн өгснөөс хойш зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна. Энэ хуулийн 14.6 заасны дагуу 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хий, бүтээц, цэвэр бохир ус,уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.
9. Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.
10. Хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 7 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зураг төсвийн дагуу гүйцэтгэнэ.
11. Гүйцэтгэгч нь барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг бүрэн биелүүлнэ.
12. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.
13. Үнийн саналд Барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөт ашиг, техник хяналт, нормчлолын сан, НӨАТ, магадлашгүй ажлын зардал зэргийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНБД "ҮҮ" 81-95-12-г мөрдлөг болгоно.
14. Автотээврийн зардлыг ЗТЯ-ны 2013.07.10-ны өдрийн 162 тоот тушаалаар батлагдсан жишиг тарифаар тооцно.
15. ЗТБХБС-ын 2012 оны 18 дугаар тушаалаар машин механизмын зардлыг тооцож ирүүлнэ.
16. Үнийн тарифийг тооцон ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.

Сайншанд сумын 2 баг "Нарлаг шанд" хорооллын 111, 113, 114, 115 дүгээр байрны гадна фасадны засал, дээврийн засварын ажил

А Ж Л Ы Н Т О О Х Э М Ж Э Э

2020/04/21

Д/д	Ажилбарын нэр	Хэмжих нэгж	Тоо
01. Гадна фасадны заслалын ажил			
1	Хуучин будагтай ханын гадаргууг торны хамт буулгах	м2	3,164.00
2	Хөндийрч суларсан дулаалгын хөөсөнцөр буулгаж солих	м2	158.20
3	Бэлэн хөөсний дээр замсаг хийж тороо цавуут зуурмагаар нааж тэгшилгээ болон хөрсжүүлэгч хийх нягт 23-25 кг/см3	м2	3,164.00
4	Гадна хананд фактурын өнгөлгөө хийх	м2	3,164.00
5	Гадна хана усан суурьтай эмульсэн будгаар будах	м2	3,164.00
6	Тагтны доод тал, амалгаа, цоколын ханын гадаргууг хусаж цэвэрлэх	м2	483.20
7	Амалгаа, тагтны хавтан ирмэг хүрээнд суурь цавуун хөрсжүүлэгч хийх	м2	483.20
8	Цонхны амалгаа, тагтны хавтангийн доод хэсэг, ирмэгүүдийг сайн чанарын усан суурьтай эмульсэн будгаар будах	м2	483.20
9	Цоколын ханын хөндийрч суларсан шаврыг ховхолж унагах	м2	46.20
10	Цоколын ханын шавардлагын засварыг цементэн шохойн зуурмагаар хийх	м2	46.20
11	Гадна цоколын хана усан эмульсэн будгаар будах	м2	153.88
12	Гадна ханан бусад заслалын ажилд 16 м хүртэл өндөр төмөр шат угсрах ба задлах	м2	254.40
02. Дээврийн ажил			
13	Дээврийн 15мм зузаан цементэн тэгшилгээ хийх	м2	331.20
14	Дараагийн 1мм зузаан тутамд үнэлгээ 30-д нэмэх	м2	4,967.60
15	Бигум массаар дээврийг бүрэх	м2	331.20
16	Налуу дээврийг 1 үе чулуутай 1 үе чулуугүй бикро элст хар цаасаар хийх	м2	331.20
17	Прапедний ханыг цемент шохойн зуурмагаар гараар сайн чанартай шавардах	м2	259.84
18	Прапедний дээр хэвтээ ус тусгаарлагч шингэн шилтэй цементэн зуурмагаар хийх	м2	129.92
19	Барилгын борооны усны хоолойг иж бүрнээр нь солих ф-100мм	м	240.00
99.Хог хаягдлын дүн			
20	Хог хаягдал	тн	0.00

Сайншанд сумын 2 баг "Нарлаг шанд" хорооллын 111, 113, 114, 115 дүгээр байрны гадна фасадны засал,

Сайншанд сум 2 дугаар баг Нарлаг шанд хорооллын 55 дугаар байрны гадна
фасадны засварын ажил

А Ж Л Ы Н Т О О Х Э М Ж Э Э

2019/11/30

Д/д	Ажилбарын нэр	Хэмжих нэгж	Тоо
01. Гадна фасадны заслалын ажил			
1	Хуучин будагтай ханын гадаргууг торны хамт буулгах	м2	2,203.96
2	Хөөсний дээр замсаг хийж тороо цавуут зуурмагаар нааж тэгшигээ болон хөржүүдэгч хийх нягт 23-25 кг/см3	м2	2,203.96
3	Гадна хананд фактуран өнгөлгөө хийх	м2	1,744.48
4	Гадна хана усан эмальсэн будгаар будах	м2	1,744.48
5	1 дүгээр давхарын 3 метрийн түвшинд дунд ширхэгтэй чулуун будагаар өнгөлгөө хийх	м2	459.48
6	Тагтны доод тал, амалгаа, цоколын ханын гадаргууг хусаж цэвэрлэх	м2	495.88
7	Цонхны амалгаа, тагтны хавтангийн доод хэсэг, ирмэгүүдийг сайн чанарын усан суурьтай эмальсэн будгаар будах	м2	269.50
8	Цонхонд усны хаялага төмөр эдлэлүүд хийх	м2	0.00
9	Гадна ханын бусад заслалын ажилд 16 м хүртэл өндөр төмөр шат угсрах ба задлах	м2	950.40
99. Хөг хаягдлын дүн			
10	Хөг хаягдал	тн	0.00

Сайншанд сум 2 дугаар баг Нарлаг шанд хорооллын 55 дугаар байрны гадна фасадны засварын ажил

